



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2006 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 532

Улаанбаатар хот

“Хотын хөгжлийн бодлогын зөвлөл”  
байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн хэтийн болон ойрын хөгжлийн бодлогыг мэргэжлийн түвшинд оновчтой тодорхойлох зорилгоор Нийслэлийн Засаг даргын дэргэд “Хотын хөгжлийн бодлогын зөвлөл”-ийг байгуулан 2006 оны 11 дүгээр сарын 25-аас эхлэн ажиллуулсугай.

Хоёр “Хотын хөгжлийн бодлогын зөвлөл”-ийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Дүрмээр хүлээсэн үүргийн дагуу нийслэлийн нийгэм, эдийн засаг, хөрөнгө оруулалт, өмч, аялал жуулчлал, газар, хот байгуулалт, үйлдвэрлэл, худалдаа, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, гамшигийн талаарх бодлогыг тодорхойлох түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг “Хотын хөгжлийн бодлогын зөвлөл” /Б.Мөнхбаатар/-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц. БАТБАЯР



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ "ХОТЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ"-ИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Хотын хөгжлийн бодлогын зөвлөл"-ийн зорилго нь /цаашид зөвлөл гэх/ "Улаанбаатар бүс"-ийн хөгжлийн хөтөлбөр, Нийслэл хотын хөгжлийн стратегийн хүрээнд нийслэлийн хот байгуулалтын бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх шатны эдийн засаг, нийгэмийн урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, хот байгуулалт, газар зохион байгуулалтын зураг төсөл, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслийн баримт бичгийг хэлэлцэн бодлого, төлөвлөлтийн шийдлээр дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино.

1.2. Зөвлөл орон тооны бус бүрэлдэхүүнтэй байх ба үйл ажиллагаа явуулах хэлбэр нь хурал байна.

1.3. Зөвлөл нь ажлаа Нийслэлийн Засаг даргад хагас жил тутам танилцуулна.

### Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

2.2. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсруулсан хот байгуулалтын болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн улсын хэмжээний төлөвлөлтийн асуудлуудад санал өгөх,

2.3. Нийслэлийн нийгэм, эдийн засаг, хот байгуулалт, газар зохион байгуулалт, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, байгаль орчны хөгжлийн хэтийн болон ойрын зорилтуудыг хэлэлцэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг тодорхойлох,

2.4. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн бодлого, нийслэлийн хөгжлийн хэтийн төлөвийн холбогдолтой хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалт, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр худалдаа зэрэг салбарын бодлогын баримт бичиг, газар хөдлөлийн бичил мужлал, инженер геологийн асуудал болон гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөтөлбөр төслийн баримт бичгийг хэлэлцэж дүгнэлт гаргах,

2.5. Нийслэлийн салбарын хөгжлийн бодлого, хэрэгжилтийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах, хуулийн төсөлд санал өгөх,

2.6. Салбарын байгууллагуудын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн хэтийн болон ойрын хөгжлийн баримт бичиг, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргах.

### **Гурав. Зөвлөлийн эрх**

3.1. Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан нийгэм, эдийн засаг, хот байгуулалт, барилгажилт, газрын харилцаа, байгаль орчны холбогдол бүхий тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх.

3.2. Зөвлөл нь нийслэлд хот байгуулалт, газрын харилцааны нэгдмэл бодлого явуулах, гарч болзошгүй эрсдэл, гамшгаас сэргийлэх зорилгоор өөрийн санаачлагаар дүгнэлт, зөвлөмж гаргах шаардлага бүхий зураг төслийн баримт бичиг, хөтөлбөр, төслүүдийн төлөвлөлтийн баримт бичиг болон үр дүнг авч хэлэлцэх.

3.3. Зөвлөлийн хуралд шаардлагатай мэргэжилтнүүдийг урилгаар оролцуулах, хэлэлцэгдэж буй асуудлын хүрээнд мэргэжлийн байгууллагаар харьцуулсан тооцоо, судалгаа, санал, дүгнэлт гаргуулах.

3.4 Зөвлөлийн хурлаас гарсан дүгнэлтийн хэрэгжилтэнд хяналт тавих, шаардах.

3.5 Нийслэлд гарч буй зөрчил маргаантай асуудлуудаар судалгаа, дүгнэлт гаргуулах, таслан зогсоох эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор хууль, дүрэм, норм нормативт өөрчлөлт оруулахыг санаачлах.

### **Дөрөв. Зөвлөлийн үүрэг**

4.1. Аливаа хэлэлцэгдэж буй асуудлыг нийгэм, эдийн засаг, хот байгуулалт, төлөвлөлтийн өндөр түвшинд, хууль дүрэм, журам, норм нормативын хүрээнд шийдвэрлэх зорилт тавин, шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник технологийн шийдлийг тусгах нөхцлийг бүрдүүлэх.

4.2. Зөвлөлийн хурлын дүгнэлтийг үндэслэн техникийн шийдлийн асуудлуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.

4.3. Төрөөс явуулж буй нийгэм, эдийн засаг, хот байгуулалтын бодлогын хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудаас нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй танилцах, санал өгөх, уялдуулах.

4.4. Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын явц, үр дүнтэй улирал тутам танилцах.

4.5 Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаараа холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцлага хүлээх.

4.6. Зөвлөлийн гишүүдийг зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй ажил хэрэгч оролцуулах нөхцлийг бүрдүүлэх.

**Тав. Зөвлөлийн ажиллах журам, зохион байгуулалт**

5.1. Зөвлөлийн гишүүд нь мэргэжлийн, мэргэшсэн болон зөвлөх эрх бүхий мэргэжилтнүүд байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.

5.2. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байна.

5.3. Зөвлөл нь сард нэг удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, гишүүдэд урьдчилан тараана.

5.4. Зөвлөл нь гишүүдийнхээ 60-аас дээш хувийн ирцтэйгээр асуудлыг хэлэлцэн олонхийн саналаар зөвлөмж, дүгнэлт гаргана.

5.4.1. Зөвлөл нь шаардлагатай тохиолдолд зарим асуудлыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хэлэлцэнэ.

5.5. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаар протокол үйлдэнэ.

оОо



125

### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ "ХОТЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ"-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- |                       |   |
|-----------------------|---|
| Зөвлөлийн дарга:      | - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга  |
| Орлогч дарга:         | - Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалтын зөвлөх   |
| Гишүүд:               | <ul style="list-style-type: none"><li>- Нийслэлийн Засаг даргын хуулийн зөвлөх</li><li>- Улаанбаатар хотын газрын ерөнхий даамал</li><li>- Улаанбаатар хотын ерөнхий инженер</li><li>- Улаанбаатар хотын ерөнхий дендерлоги</li><li>- Нийслэлийн нийгмийн даатгалын газрын дарга</li><li>- Нийслэлийн Нийтийн тээвэр зохицуулалтын газар</li><li>- Нийслэлийн Автозамын газар</li><li>- Нийслэлийн Байгаль хамгаалах газар</li><li>- Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний автор архитектор</li><li>- Усны хэрэг эрхлэх газрын зөвлөх</li><li>- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн зөвлөх</li><li>- Монголын Архитекторуудын Эвлэл</li><li>- Гэр хорооллын оршин суугчдын эрх ашгийг хамгаалах холбоо</li><li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс</li><li>- Нийслэлийн Барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газрын хэлтсийн дарга</li></ul> |
| Нарийн бичгийн дарга: | - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн  |